

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 9 ДҮГЭЭР САРЫН  
07-НЫ ӨДӨР /БЯМБА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-6
<b>2.</b>	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-25
<b>1</b>	1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг дагаж мөрдөх хугацаа	7-11
	2.Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	11-25

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 9 дүгээр сарын  
07-ны өдөр /Бямба гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаан ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн ирж 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 07 минутад Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Батзандан;

Тасалсан: О.Баасанхүү, Б.Наранхүү, Д.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбат.

**Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг дагаж мөрдөх хугацаа**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, А.Солонго, Б.Хатантуул, референт Б.Золбоо, Ж.Ганчимэг, Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн шинжилгээний албаны шинжээч Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 12 цагаас эхлэн улс даяар мөрдөнө гэсэн төслийн заалтыг танилцуулав.

Төслийн заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар нар үг хэлэв.

**С.Бямбацогт:** 1.Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Төслийн 6 дугаар зүйл. Дагаж мөрдөх хугацаа.

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 12 цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэсэн төслийн заалтыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	13
Бүгд:	14

7.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, **6 дугаар зүйл**. Дагаж мөрдөх хугацаа.

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу 17 дугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны рашаан барилдлагатай өлзийт сайн шар луу өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	1
Бүгд:	14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын гишүүд 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга

Л.Өлзийсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Парламентын ардчиллыг төлөвшүүлж, ард түмний засаглах эрхийг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлж, хараат бус байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа, А.Солонго, Б.Хатантуул, референт Б.Золбоо, Ж.Ганчимэг, Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн шинжилгээний албаны шинжээч Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт уг асуудлыг хэлэлцэхтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24<sup>7.6</sup>-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон энэ хуулийн 23.5-д заасан бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг мөн хуулийн 21-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно гэсэн заалтыг уншив.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт хуулийн төслийг танилцуулав.

*Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулав.*

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Төслийн 3, 4, 5 дугаар зүйлийг хасаж, шинээр заалт нэмье гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргав.

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг, Б.Баттөмөр, Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Баасанхүү, Д.Дамба-Очир нарын гаргасан, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль, тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан, шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар, Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 2  
Бүгд: 14  
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Энэ хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

**6.Нэгдүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтлана. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 1  
Бүгд: 14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцангийн гаргасан, 43.1 “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүн хурлын нийт гишүүдийн олонхи уг саналыг дэмжсэн бол “Ерөнхий сайдыг огцруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 2

Бүгд: 14

85.7. хувийн саналаар дэмжигдлээ.

8. 22.3. Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн, Д.Лүндээжанцан, С.Бямбацогт нарын гаргасан, Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш 45 хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9. хувийн саналаар дэмжигдлээ. /найруулгатайгаар дэмжлээ/

9. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 1

Бүгд: 14

92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгохтой холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахтай холбоотой нэмэлт, өөрчлөлтийн дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ ажлын хэсгийн гишүүд болон Байнгын хорооны гишүүдэд хандан хуулийн бичилт, үг сонголт, үг, үсэг, агуулгын алдаа зэрэг дээр онцгой анхаарч ажиллахыг анхааруулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан энэ асуудал дээр хэлний зөвлөл ажиллаж байгааг онцлов.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 20 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2019 ОНЫ  
9 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР /БЯМБА ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Бямбацогт:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ирц хүрсэн биз дээ. Тийм ээ.

Байнгын хорооны хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 68.4 хувийн ирцтэй байна. Энэ өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг дагаж мөрдөх хугацааг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019 оны 6 сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалд орох уу? Хэлэлцэх асуудалдаа оръё. Өөр санал алга байна.

Ажлын хэсгийг танилцуулъя. Хуралдаанд оролцож байгаа. Н.Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч, ажлын дэд хэсгийн ахлагч, Д.Ламжав Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, Р.Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Ц.Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, О.Мөнхсайхан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор, ажлын дэд хэсгийн ахлагч, А.Бямбажаргал Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор, О.Машбат Үндсэн хууль судлаач. Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Өргөн мэдүүлсэн төслийн заалтыг би уншиж танилцуулна. Тийм ээ. Эхлээд. Дараа нь үүнтэй холбоотойгоор гишүүд саналаа хэлэх байх.

Нэгдүгээрт нь, Үндсэн хууль. Эхний асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний 12 цагаас эхлэн улс даяар мөрдөнө гэсэн заалтыг Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн өргөн мэдүүлсэн байгаа. Энэ заалтыг одоо хэлэлцэнэ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 1 сарын 01-нээс эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэсэн саналыг бас өргөн мэдүүлсэн байгаа. Улсын Их Хуралд.



Хэлэлцэх асуудалтай холбогдуулж зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэзээнээс дагаж мөрдөх вэ гэдгийг.

2020 оны 7 сарын 01-нээс өргөн мэдүүлнэ гэсэн үндсэн төсөл байгаа. Төслийн заалт нь. Нөгөө нэг, зарчмын зөрүүтэй санал хураалгах юм аа яасан.

Д.Лүндээжанцан гишүүн. Зарчмын зөрүүтэй санал. Үг хэлэх гишүүн. Д.Лүндээжанцан гишүүн саналаа хэлье.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр ингэж байгаа юм. 7 сарын 01-н бол сонгуулийн дараагаас эхэлж, яг хүчин төгөлдөр болох нь сонгуулийн дараа болчихоод байна. Тэрнээс жаахан нааш нь татах ёстой гэдэг ийм саналууд гарсан.

Ерөнхийлөгчийн санал бол 1 сарын 01-нээс байгаа. Тэгэхээр яах вэ, 1 сарын 01 хүртэл бол бас энэ ард нийтийн санал асуулга явагдах учраас цаг хугацаа орно. Энэ бүхэнтэй холбогдуулаад дагаж мөрдөх хугацааг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу Арвандолдугаар жарны Төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны рашааны барилдлагатай өлзийт сайн шар луу өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гээд. Ийм томъёоллоор оруулъя гэдэг ийм саналыг манай ажлын хэсэг дээр яригдсан.

6 сарын 08-ны өдөр бас сайн өдөр байна. Энэ уламжлал бол бид бүхэн юутай холбогдож байгаа вэ гэхээр манай одоогийн Үндсэн хууль маань Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу Арван долдугаар жарны Усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэдэг ийм уламжлалт энэ зурхайн ёсыг бас баримтлах нь зүйтэй гэж үзсэн.

Тийм учраас бид бас өдөр, сар, гараг, барилдлага, тэгээд мэнгэ гээд ингээд олон шалгуурууд байдаг юм байна. Энэнээсээ үндэслэж байгаад одоо энэ зурхайн шинжлэх ухаан дээр үндэслэсэн зуны тэргүүн сар гэдэг бол одоо маш хамгийн гол сар байдаг. Тэгээд шинийн гурван буюу Балжиннямтай өдөр байгаа энэ өдөр. Ийм учраас бүх юм өрнөн дэлгэрэхийн. Тэгээд рашааны барилдлага гэдэг бол их сайн барилдлага гэж үздэг. Өөрөөр хэлбэл одоо анагаах чадвартай. Хүн болгон л рашаан болдог ийм бэлэг дэмбэрэлийг бас Монголчуудын бэлэг дэмбэрэлийн ёсыг бас бодсон. Энэ 5 сарын 25-ны өдөр гэдгийг оруулж байгаа юм.

Хүчлэн бүтээхтэй холбоотой бар өдөр ингээд 6 сарын 28 байгаа. Энэ 6 сарын 28-ны өдөр бол сонгууль яг явагдаж байгаа энэ үе таараад байгаа юм. Тийм учраас сонгуулиас арай өмнө хийх нь зүйтэй.

6 сарын 08-ны өдөр бол идрийн барилдлагатай. Бас сайн өдөр байгаа. 2 сарын 29 буюу өндөр жил гэдэг дээр бас судалж үзсэн. Бар өдрийн төмөр бар цаг гээд.

Энэ болгоныг үзэж байгаад 2 сарын 29 буюу одоо ингээд сарын сүүлчийн өдөр байгаа юм. 6 сарын 28 бол одоо хамгийн тохиромжтой өдөр гэж, тэгэхдээ Ням гараг болчихоод байгаа юм. Гэх мэтчилэнгээр их олон талаас нь авч үзэх учиртай учраас Даваа гараг байгаа. 5 сарын 25 бол. Энэ өдрийг сонгож авбал тэр тооны болоод одон гараг эрхэсийн тэр шинжлэх ухаантайгаа бас хүндэтгэн үзэж.

Дээр нь 1992 онд Үндсэн хуулиа дагаж мөрдсөн уламжлалаа баримтлах ийм олон зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр Монголчуудын өн удаан жилийн зуны эхэн сарын шинийн гурван гэдэг өдрийг сонгож авч байна. Тэгсэн маягаар одоо бид саналаа оруулж байгаа юм.

**С.Бямбацогт:** Их Хурлын дарга. Г.Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Өдрийн сайныг өнжин хүлээж, сарын сайныг саатан хүлээж гэдэг шиг ингээд өдөр судраа харж яах нь Монгол ёс.

Гэхдээ нэг ийм асуудал байгаад байх юм. Тамгын газар, ажлын хэсэг анхаарвал. Энэ өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэхэд нөгөө Дагаж мөрдөх журмын тухай хуулиар болон бусад хуулиар зохицуулах шаардлагатай асуудлууд гарах уу? Жишээлбэл, нөгөө Дархан, Эрдэнэт хотуудыг хот болно гээд тэгэхээр эндээ шууд заасан байсан өөрчлөлт байхгүй болсон юм шиг байх юм. Тэгээд Дархан, Эрдэнэтийн асуудлаа нэг байх.

Хоёрт нь, энэ дээр орж байгаа тодорхой өөрчлөлтүүдээр. Жишээлбэл, давхар дээлийг хязгаарласан. Давхар дээлийг хязгаарласан заалтуудыг чинь тухайн Засгийн газар бүрдэх үед гэдэг юм уу, хэзээ бүрддэг юм, тийм ээ. Тэр үед чинь 6 сарын өмнө нөгөө хуулиуд нь өөрчлөлт орсон байх шаардлагууд гарах уу? Бусад бүх цогцоороо энэ дотор нь орохгүй ч гэсэн. Дараагийн юмнууд. Энийг нэг анхаараад.

Тэгээд бас дараагийн асуудалдаа ч гэсэн нэг мөр хэлэхэд жишээлбэл, Ерөнхийлөгчийн сонгуулиар хэрэгжиж эхэлнэ гээд. Тэгэхээр нөгөө сонгуулийн хууль чинь 6 сарын өмнө 6 жил болно. 50 нас хүрсэн байна гэсэн шаардлагууд чинь Сонгуулийн хууль чинь 6 сарын өмнө батлагдах ёстой болно шүү дээ. Ерөнхийлөгчийн сонгууль чинь. 2020 оны 12 сарын 31-ний дотор.

Тэгэхээр 12 сарын 31-нээс өмнө Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд, Ерөнхийлөгчийн хуульд өөрчлөлтүүд оруулах шаардлагатай болохоор хүчин төгөлдөр болоогүй хуульдаа нийцүүлж хууль өөрчилдөг юм уу? Хууль зүйн техникийн хувьд тэрийгээ бодохгүй бол. Яг тулгаад заачихдаг. Тэгтэл нөгөө хуулиа өөрчилж болохгүй болох тийм эрсдэлүүд гарах юм биш биз. Яагаад гэхээр 50 нас хүрсэн гэсэн шаардлага тавигдах болтол. Тэрийгээ хүн чинь 6 сарын өмнө ч юм уу хуулиар тодруулсан байх ёстой болно шүү дээ, тийм ээ. Тэгтэл тэр хуулийг нь батлах гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлт нь ороогүй. 45 гэдэг нь хэвээрээ байхаар хуучин Үндсэн хуулиараа хүн нэр дэвших болчих гэсэн энэ тэр ийм зөрчлүүд энэ дагаж мөрдөх хугацаатай гарахгүй байх асуудлыг нь нарийвчлан тооцсон уу гэсэн асуулт, тодруулга, санал юм уу даа.

Мэдээж өдөр судар бол сайн өдрөө үзэж харах нь зүй ёсны хэрэг.

**С.Бямбацогт:** Энэ Дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэлэлцэх асуудал хоёр дахь асуудалд байж байгаа. Дараа нь бид нар хэлэлцэнэ. Гэхдээ саяны анхаарах юмнууд байгаа. Бэлтгэлийг хангах.

Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална гэсэн ийм заалт орж байгаа. Тийм болохоор үндсэндээ Үндсэн хууль шинэчлэн батлагдаад тухайн харилцаа ингээд хэрэгжиж эхлэх хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хууль бол явж л байна. Тийм болохоор нэг их айхтар зөрчил гарахгүй.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж зохион байгуулна гэсэн байж байгаа. Тэгэхээр одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулаад дараад нь яг тодорхой ямар хуулиудыг ямар хугацаанд, хэзээ батлах вэ, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө аль хуулиудыг батлах вэ, явцын дунд алиныг нь батлах вэ, хүчин төгөлдөр болсны дараа бас явцын дунд баталж болох уу гэдгээ бид нар шийдэхээ дагаж мөрдөх журмын тухай хуулиар шийдчихнэ.

Саяны тэр Ерөнхийлөгчтэй холбоотой заалт дээр сая Их Хурлын дарга хэлж байгаа бас гарцаа байхгүй бас анхаарах асуудал. Тийм болохоор бид нар зүгээр зарчмын зөрүүтэй санал дээр 2025 оныг 2021 он болгоё гэж ярьсан байгаа. Гэхдээ өөр бас нэг жаахан наашлуулж 2021 оны сонгуулиас энэ хууль маань үйлчилж ирэхээр Үндсэн хуультай холбогдох хуулиудын өөрчлөлтийг оруулах гэдэг юм уу. Тийм ээ. Энэ бололцоо боломжийг бүрдүүлэх үүднээс манай ажлын хэсэг бас томъёолол бэлдэж байхгүй юу. 2021 оны 7 сарын 01 гэдгийг. Тийм үү. Одоо 2025 оны 7 сарын 01 гэдгийг нь наашлуулахдаа үндсэндээ шинэ 2021 онд болох Ерөнхийлөгчийн сонгуулиар энэ хууль маань хэрэгжээд эхэлсэн байхаар бас энэ томъёоллыг бас бодоосой. Их Хурлын даргын өгсөн саналын дагуу бас анхаарч байгаачээ гэдгийг бас хэлье.

Ингээд зарчмын зөрүүтэй өөр санал байна уу? Д.Лүндээжанцан гишүүний гаргасан. Д.Лүндээжанцан, С.Бямбацогт, Д.Тогтохсүрэн нарын гаргасан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу Арвандолдугаар жарны Төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны рашаан барилдлагатай өлзийт шар луу өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө гэсэн санал гарсан.

Өөр санал байхгүй байна уу? Байхгүй бол эхлээд төслийн заалтаар хураалгана. Эхлээд төслийн заалт. Төслийн заалтаа хураалгачихъя.

Нэгдүгээрт нь, энэ бүгдээрээ Үндсэн хуулийн нөгөө зүйл, заалттай адилхан гуравны хоёрын босготой. Гишүүд бас анхааралтай байхыг хүсье.

1.Төслийн 6 дугаар зүйл. Дагаж мөрдөх хугацаа.

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 12 цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө. Төслийн заалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92.9 хувь нь дэмжсэнгүй. Энэ саналыг дэмжсэнгүй.

1.1. Дараагийн санал хураалт. Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

6 дугаар зүйл. Дагаж мөрдөх хугацаа.

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу 17 дугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны рашаан барилдлагатай өлзийт сайн шар луу өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Лүндээжанцан, Тогтохсүрэн.

2020 оны 5 сарын 25-ны өдөр буюу. За дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 92.9 буюу 13 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Баярлалаа.

**Дараагийн асуудалдаа оръё.**

**Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя.**

Дэгийн тухай хуулийн 24<sup>7</sup>.6-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуулийн 21-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж баталж болно гэж заасан байгаа.

Тэгэхээр үүний дагуу тодорхой саналууд бас гаргах бололцоо байгаа. Тэр түрүүн ярьсан Дархан, Эрдэнэттэй холбоотой асуудлууд, Ерөнхийлөгчийн сонгуулийн дагаж мөрдөх, манайхан бэлдэж байгаа юу.

Ажлын хэсгийг танилцуулъя. Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч ажлын дэд хэсгийн ахлагч, Ламжав Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, ажлын дэд хэсгийн ахлагч, Мөнхсайхан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, хууль зүйн ухааны доктор, ажлын дэд хэсгийн ахлагч, Бямбажаргал Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор, Машбат Үндсэн хууль судлаач ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Дагаж мөрдөх журмын тухай хуулийг та бүхэнд бас нэг уншаад танилцуулчихъя.

Нэгдүгээрт нь, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт,

өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гэсэн ийм төслийн заалт байгаа.

2 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025 онд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө. Төслийн заалт.

Энэ дээр ажлын хэсгээс саналын томъёолол бэлдмээр байна. Сая Их Хурлын даргын өгсөн бас саналыг харгалзаад. 2021 оны 7 сарын 1-нээс Ерөнхийлөгчийн сонгууль болоход энэ хуулийн үндсэндээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь хүчин төгөлдөр болчихсон байх. Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон байхаар энийг нааш нь татсан саналын томъёолол бэлдээдэхээч ээ гэж одоо бас хүсье.

3 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид хамаарахгүй. Төслийн заалт.

Энэ бол үндсэндээ хасагдсан учраас энийг бол хасах байх.

4 дүгээр зүйл. 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Улсын дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 12 жил байна. Төслийн заалт байгаа. Энэ бас хөндөгдөөгүй учраас хасагдах байх.

5 дугаар зүйл. 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Энэ бас хасагдсан дэмжигдээгүй учраас бас хасах шаардлагатай болох байх.

6 дугаар зүйл. Энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй. Төслийн заалт.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм төслийн заалт байгаа.

Төслийн заалттай холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Асуух асуулттай. Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байна уу? Зарчмын зөрүүтэй санал Тогтохсүрэн дарга уу. Та гаргачих нь дээр байх аа.

**Д.Тогтохсүрэн:** Би хэлэх үү. Ийм санал байгаа шүү дээ. 4 дүгээр заалт. Төслийн би юу хэлэх вэ. Зарчмын зөрүүтэй санал хэлье, Бямбацогт даргаа.

Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлийг хасах саналтай байгаа юм. 2 нь найруулагдана, 3, 4, 5 дугаар зүйлийг хасах саналтай байгаа юм. Энэ нөгөө Үндсэн хуулийн 2 дугаар хэлэлцүүлэг дээр сая 57 гишүүний дэмжлэг авч чадаагүй заалтууд. 3, 4, 5 дахь нь. Нөгөө шүүхтэй холбоотой, Улсын дээд шүүхтэй холбоотой, Цэцтэй холбоотой заалт байсан. Тэгэхээр энэ 3 заалтыг хасья гэсэн горимын санал, юу зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

Хоёр дахь санал нь төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид шинэчлэн баталсны дараа 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж оруулж байгаа юм.

Энэ нь нөгөө Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл хоёр байгаа юм. Энэ хуулийг нь батлах хугацаа нь яваад, ажлын хэсэг дээр ярьж байгаад, 2021 оны 7 сарын 01-нээс гэвэл яасан юм бэ гэж байгаа юм. Ийм зарчмын зөрүүтэй 3, 4, 5, тэгээд шинээр тэр 3, 4 дэх заалтыг нь болгоод, саяны заалтыг шинээр нэмье гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

**С.Бямбацогт:** Өөр зарчмын зөрүүтэй саналууд байна уу? Нэг мөсөн зарчмын зөрүүтэй саналуудаа авчихъя. За тэр 5 дугаар төсөл дээр би бас зарчмын зөрүүтэй санал байгаа юм. Мөнхсайхан ажлын хэсгийн дэд ахлагч бэлдээдэхгүй юу.

Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн баталсны үндсэн дээр 2021 оны 7 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө гэж санал сая Тогтохсүрэн гишүүн гаргаж байна. Би бол энэ Шүүгчийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй заалтыг ер нь Үндсэн хууль батлагдаад энэ өдрөөс хойш хүчин төгөлдөр болохоор санал гаргаж байна. Энэ томъёоллыг бэлдээдэх дээ.

Аль асуудал дээр. Лүндээ гишүүн эхлээд дараа нь.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр би бол ингэж бодоод байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусганаа гээд. Хуваарь гаргах нь байна, тийм үү. Энэ хуулиудыг гаргахдаа Бямбацогт дарга аа, та Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо энэ тэр ингээд шууд орно гээд байна шүү дээ. Гэтэл тэр хуулиудыг өмнө нь гарганаа. Гаргахдаа тэр хуулиудын хүчин төгөлдөр болох хугацааг хийхдээ манай Тамгын газрынхан сайн анхаарч байгаарай. Хийхдээ Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхэлж дагаж мөрдөхөөр хийх асуудал байгаа юмаа.

Өөрөөр хэлбэл, би тэгж бодоод байна шүү дээ, энэ миний ойлголт зөв байна уу, буруу байна уу? Нэг ойлголцолд орохгүй бол болохгүй байна, чуулган руу. Тэгээд ер нь цаашдаа ч гэсэн Үндсэн хууль хүчин төгөлдөр болоогүй байхад энэ хуулиудыг чинь баталж болох юм уу, үгүй юм уу. Зохион байгуулалт хийж болох юм уу, үгүй юм уу гэдэг асуудал яригдана аа даа. Тэгвэл Нутгийн удирдлагын хуулийг одоо эхний хагас жилд багтаа гээд, энэ, Журмын хуульд байж байна шүү дээ тийм үү, үгүй юу.

За тэгэхээр, тэр Дархан, Эрдэнэт хоттой холбоотой, мөн нутгийн удирдлагатай холбоотой энэ асуудлуудыг, хуулийг хэлэлцээд батална, хуваарийн дагуу. Батлахдаа, хүчин төгөлдөр болох хугацаанууд нь цөм 5 сарын 25-аас хойш хэрэгжих нь байна шүү дээ гээд энэ ойлгоцоор, тэгэхээр бол 5 сарын 25 хүртэл юу ч хийхгүй, гар хумхиад суугаад байхгүй нь. Энэ хугацаанд хуулиудаа батлахыг нь батлаад явна. Дагаж мөрдөхдөө бол 5 сарын 25-нд

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдангуут үйлчлээд явна гэж ингэж ойлголцож болж байна уу, үгүй юу? Манай ажлын хэсгийнхэн хэлээд өгөхгүй бол, бид нар яг Занданшатар даргын асуулттай яг адилхан болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм хуулиуд байж байна, Шүүхийн хуулиуд, Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль бол мэдээж хэрэг, тэр 2021 онд сонгуультай учраас тийм үү, энэ заалт нь 7 сарын 01-ээс үйлчлээд, хуулийг нь бол өмнө нь, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчинтэй болохоор батлагдаад явчихна. За тэр давхар дээлтэй холбоотой хуулиудыг нь бид өмнө нь баталчихна, өмнө нь баталсны дараа, Үндсэн хууль хүчин төгөлдөр болсноос хойш, дараагийн Засгийн газраас энэ явна аа гэдгийг нь хуулийнхаа өөрчлөлтөд хийгээд өгчихнө өө. Энэ мэтчилэн ингээд явчихна аа гэж, би ойлгож байна. Тэгэхээр миний энэ ойлголт байна шүү дээ, өөр бас нэг тайлбар гарч ирээд, маргаан үүсгээд байх вий гэдэг үндсэн дээр, би протоколд үлдэх, ойлголтоо нэгтгэх үндсэн дээр ярьж байгаа юм шүү. Энэ ажлын хэсгийнхэн гар өргөөд, үүнийг сонсчих уу.

**С.Бямбацогт:** За, ажлын хэсгийг сонсчихъё, дараа нь Мөнхбат гишүүн. Лувсанжав гуай, дараа нь Товуусүрэн гуай.

**Н.Лувсанжав:** Энэ, нэгдүгээр зүйл байгаа шүү дээ, нэгдүгээр зүйлд Үндсэн хуулийн, энэ хууль маань Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй гээд хэлчихсэн байгаа. Ганцхан, энэ хуваарийн дагуу хэдийд хийж дуусгах юм бэ гэдэг хугацааг нь тодорхой болгоод, 2020 ондоо хийж болохоор, 2020 оны 7 сарын 01-нээс өмнө хийж болохоор хугацааг нь заагаад өгчих юм бол, энд асуудал гарахгүй шүү дээ. Нэг тийм юм бодогдож байна. Түрүүн Занданшатар дарга ярьсан, тэр Ерөнхийлөгчийн Сонгуулийн хууль 2021 оны 7 сарын 01-нээс өмнө, өөрөөр хэлбэл, 2020 оны 7 сарын 01-нээс өмнө бараг, батлагдах ёстой гэсэн ойлголтоор асуугаад байх шиг байгаа юм. Тэгэхээр зэрэг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол Их Хурлын сонгуулийн хуулийг л жилийн өмнө, жилийн дотор өөрчлөлт оруулахыг хориглосон шүү дээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд бол энэ хамаарахгүй. Тийм учраас, Их Хурлаас баталсан хуваарийнхаа дагуу, 2021 оны 7 сарын 01-нээс өмнө, сонгуулиас өмнө, хуулиа баталсан байхаар хуваариа гаргаад, батлаад мөрдөөд явахад, болох байх л гэж бодох юм. Тэгж л ойлгож байна л даа.

**С.Бямбацогт:** За Товуусүрэн гуай. 2 дугаар микрофон.

**Ц.Товуусүрэн:** Лувсанжав бараг хэлчихлээ дээ. Энэ хууль, Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр учраас, энэ хуулийн дагуу хууль, тогтоомжуудынхаа Улсын Их Хурал батлах хугацааг тогтоогоод, мөрдөх хугацааг нь Лүндээжанцан гишүүний хэлснээр яахад ямар нэгэн зөрчил үүсэхгүй ээ гэж харж байгаа. Ер нь Ерөнхийлөгчийн, энэ 2 дахь заалтыг хэдэн хэсэгт боловсруулаач гээд байх шиг байна. Энэ 2 дахь заалтыг хасчихад болно. Яагаад гэвэл, тэр графиктаа оруулаад, төдийд боловсруул гээд хийхэд бол бололцоотой гэж бодож байна аа. Бусдыг нь Лувсанжав хариулчихлаа. Тэр зарчмын зөрүүтэй санал бодвол тэр Дархан хот, Эрдэнэт хотоор гарч ирэх байх гэж харж байгаа шүү дээ.

**С.Бямбацогт:** За, Мөнхбат гишүүн.

**Ж.Мөнхбат:** За, гишүүдийн өглөөний мэндийг айлтгая. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийн хугацаа дээр хэд, хэдэн зүйлийг анхаарах юм байгаа. Энэ дээр Ерөнхийлөгчтэй холбоотой нэг хэсэг заалт орж ирж байгаа, шүүхтэй холбоотой хэсэг заалтууд орж ирж байгаа. Тийм учраас, Улсын Их Хурлын сонгуультай холбоотой нэгдүгээрт яах вэ гэхээр, 2020 оны сонгууль 6 сар гаргаад болох байх, тэгэхэд ямар нэгэн хуулийн маргаангүй байхаар, нэгдүгээрт анхаарах нь зөв байх аа. Би 2 дахь зарчмын санал нь бол Ерөнхийлөгчийн, одоо, хэрэгжиж эхлэхтэй холбоотой байр суурь, саналыг сонссон уу, ер нь энийг сонсох нь зөв байх шүү. Ерөнхийлөгчөөс саналыг нь аваад, сонсоод, Ерөнхийлөгчтэй холбоотой заалтууд мэдээж одоо, 25 гээд төслөөр орж ирсэн, одоо 21 болоод явах гэж байх шиг байна, шүүхийн зарим зүйл, сая Бямбацогт даргын яриад байгаа сахилгын хороо, энэ тэр дээр нь ямар саналтай байгаа юм бэ, наадах чинь Ерөнхийлөгчийн бас томилгоотой, шүүхийн зарим томилгоо чинь Ерөнхийлөгчөөс хамааралтай байгаа, тэгэхээр ийм байр суурь байгаа учраас Ерөнхийлөгчийн санал, байр суурийг сонссон нь зөв байх шүү гэсэн ийм саналыг хэлье ээ гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Ерөнхийлөгчийн саналыг би асуусан, байр суурь ямар байна аа гэсэн, энэ дээр, Шүүхийн ерөнхий зөвлөл, сахилгын хороотой асуудал бол нэгэнтээ шүүх, шударга шүүх, хараат бус болох гэж байгаа бол, энэ заалтаа аль болох хурдан үйлчлүүлж эхлэх нь зөв өө. Заавал 2021 оны 7 сарын 01 гэх шаардлагагүй ээ, гэдэг санал хэлсэн. Шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол, дараагийн сонгуулиасаа эхлээд хэрэгжээд эхэлсэн байхаар байх нь зөв байх аа гэсэн саналууд хэлсэн байгаа. Гэхдээ Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргыг дуудчихгүй юу. Байр суурийг нь сонсьё, тийм ээ, бас баталгаажуулж. За, Тамгын газрын даргыг дуудчихаарай, бас асууя. Бас, байр суурийг нь сонсьё. За нэгдүгээрт нь бусад зүйл, заалтуудаараа саналаа хураачихъя, тэгэх үү. За тэр, 2 заалтыг түр хойшлуулчихъя.

За, нэгдүгээрт нь, Тогтохсүрэн гишүүн гаргасан, төслийн 3 дугаар зүйлийг хасья гэсэн санал гаргаж байна аа, Тогтохсүрэн гишүүн. За дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя, олонх нь дэмжиж байж явах ёстой шүү, Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй гэж байгаа учраас. Дөрөвний гурваар тийм. За, Тогтохсүрэн гишүүн өөрөө хааччихав. Гуравны хоёроор тийм. За дуудъя. Сумъяабазар сайдыг бас.

За, Дархан, Эрдэнэтийн саналыг сонсьё, Содбилэг гишүүн, зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа.

**О.Содбилэг:** Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Эрдэнэт, Дарханы нийт 6 гишүүдээс, ийм санал гарсан байгаа, би уншаад танилцуулчихъя. Төсөлд, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр, Засгийн газар, Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ гэсэн зүйлийг нэмэх, гэдэг ийм санал гаргасан. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содбилэг, Баттөмөр, Жавхлан, Хаянхярваа, Баасанхүү, Дамба-Очир нар.

**С.Бямбацогт:** За, энэ зарчмын зөрүүтэй гаргасан саналаар, санал хураалт явуулчихъя. Саяын төсөлд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль, тогтоомжийг 2020 оны эхний хагас



жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар, Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ гэсэн зүйл нэмэх. Санал гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Содбилэг, Баттөмөр, Жавхлан, Хаянхярваа, Баасанхүү, Дамба-Очир гэсэн санал байна аа, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

14 гишүүн санал хураалтад оролцож, 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Лүндээжанцан, Тогтохсүрэн, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт явж байгаа шүү, гишүүд ээ.

14 гишүүн оролцож, 12 гишүүн буюу 85.7 хувийн саналаар, энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Лүндээжанцан, Тогтохсүрэн, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

100 хувийн саналаар, 14 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалт.

Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Лүндээжанцан Тогтохсүрэн. Санал гаргасан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

100 хувь санал буюу 14 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Энэ хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Лүндээжанцан, Тогтохсүрэн.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Дагаж мөрдөх журмын тухай хуулийг. 11 сарын 26. Санал хураалт. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүчинтэй хугацаа.

Мөнхбат гишүүн санал гаргаж байна шүү. Ажлын хэсэг дээр Мөнхбат гишүүний саналыг нэмээрэй.

Тамгын газрын даргатай ярьж холбогдсон уу? Ирж байна уу?

Санал хураалт гишүүд анхааралтай байгаад, саналын томьёоллыг уншиж танилцуулья. Гишүүд анхааралтай байгаарай.

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтлана. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Төслийн заалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Хийж дуусгана.

Дэмжээрэй, дараа нь ярь. Анхаарал битгий сарниул. Ер нь график байгаа, гарсан байгаа. Намрын чуулганаар ярина.

14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тав дахь санал. Төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийн 48.1 дэх хэсэг, 49.5,6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн баталсны үндсэн дээр 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө гэсэн зүйлийг хасъя. Энэ байхгүй биз дээ. Үгүй үгүй, угаас байхгүй шүү дээ.

Лүндээжанцан гишүүн саналаа гаргая.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр өчигдөр хоёрдугаар хэлэлцүүлэг дээр санал хураагаад, Мөнхбат гишүүний санал дэмжигдсэн.

“Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно” гэж дэмжлэг авсан байхгүй юу. Түүнийг тогтоол батлагдсанд тооцож Шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гээд, нөгөө Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тогтоолын төсөл оруулбал, дэмжлэг авахгүй бол огцорсонд тооцож шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гэдэг тэр заалтыг ижилхэн болгох хууль зүйн техникийн шаардлага байна.

Хоёрдугаарт, үүнтэй холбогдуулаад 22.3-т Ерөнхийлөгч Үндсэн хуулийн 39.2 дахь хэсэгт заасны дагуу “Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш 45 хоногийн дотор, эсвэл Үндсэн хуулийн 43.1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас түүнчлэн 44.2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана” гэж байгаа.

Тэгэхээр тэр 44 дүгээр зүйл гэдэг нь угаасаа урд талд нь огцорсонд тооцоод, 30 хоногийн дотор Ерөнхий сайдыг томилж, шинэ Ерөнхий сайдыг томилоогүй бол Их Хурлыг тараана гэсэн энэ заалт өмнө нь байгаа учраас яг ижилхэн хоёр асуудал, тэгэхээр үүнийг нийлүүлээд ийм найруулгын засвар оруулахаас аргагүй байгаа юм.

Үүнийг эндээ санал хураагаад, юуны төгсгөлд, бас нэг санал үлдсэн, санал хураагдаагүй гэсэн яриа гараад байгаа. Энэ бол Нямбаатарын хойшлуулсан санал байгаа, тэр яг хураагдсан байна уу, гэхдээ тэр чинь татах хамаагүй шүү дээ, тэр зарчмын зөрөөтэй санал биш, төслийн санал явж байгаа байхгүй юу.

Тийм учраас хурааж, түүнийг нэг тийш нь болгоод унагах шаардлагатай байна. Түүнийг манай Тамгын газар бүр сайн лавлаад, мухарлахгүй бол хоёрдугаар хэлэлцүүлэг дээр тийм саналтай болох гээд байгаа байхгүй юу.

Хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа зөрчилтэй санал үлдэх гээд байгаа юм. Баг, хорооны засаг дарга, аймаг, нийслэл, сум дүүрэг энэ чинь бүр зарчмын зөрүүтэй, түүнийг санал хураахдаа үүнийг хамт хураагаад, тэгээд дагаж мөрдөх журмыг хураагаад ийм гурван санал хураалт явуулах шаардлага хоёрдугаар хэлэлцүүлэг дээр гарах юм байна гэж, үүнийг би дагаж мөрдөх хугацаагаа яаж байж хоёрдугаар хэлэлцүүлэг дуусах байхгүй юу. Одоо ингээд ороод. Үүнийг Бямбацогт дарга уншаад хураалгаад өгөөрэй гэж.

**С.Бямбацогт:** Сая Лүндээжанцан гишүүн бас өчигдрийн санал хураалтаар холбоотойгоор сая санал гарлаа. Энэ бол хураагдах саналууд байгаагүй, яагаад гэвэл төслийн заалт дэмжигдсэн бол өөрчлөлт орохгүй байсан, төслийн санал дэмжигдээгүй, гишүүний санал дэмжигдсэн учраас түүнтэй холбоотойгоор зайлшгүй ярих шаардлага үүссэн. Тийм учраас энэ саналыг хурааж, чуулган руу оруулах ёстой гэж бодож байна. Тийм болохоор санал хураалт явуулья.

Хоёр заалттай, хоёулангаар нь явна шүү дээ, Дэмжинэ. Хоёуланг нь дэмжинэ.

Нэгдүгээр санал хураалт. 43.1. “Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн, 10 хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын гишүүн хурлын нийт гишүүдийн олонх уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно”.

Урьд нь хуучин Ерөнхий сайд огцронгуут дараагийн нэр дэвшүүлсэн Ерөнхий сайд томилогддог автомат заалт байсан. Тэр заалт унасан учраас одоо шинэ Ерөнхий сайдыг томилох хугацааг бас оруулж өгөх ёстой болж байгаа юм.

Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтанд 14 гишүүн оролцсоноос 12 гишүүн буюу 85.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ заалт дэмжигдсэнтэй холбоотойгоор дахиад санал хураалт явагдах ёстой. Үндсэн хуульдаа утга агуулгын хувьд зөрчилтэй заалтууд байх ёсгүй. Тийм үүднээс хураагдаж байгаа.

22.3. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас, түүнчлэн 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш 30 хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана. Санал

гаргасан Мөнхбат, Тогтохсүрэн, Лүндээжанцан, Бямбацогт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо нэг санал үлдсэн. Энхболд дарга ирж байна уу? Товуусүрэн гуай. Ажлын хэсэг, 2 дугаар микрофон.

**Ц.Товуусүрэн:** Сая бүхлээр нь уншаад хураалгачихлаа л даа. Тэгэхээр хуучин баталсан юмаа энэ юмтай холиод унагачих вий гэдэг болгоомжил л байна. Тийм учраас нэмж байгаа зүйлээрээ томьёолж санал хураалгах нь зөв шүү. Тэгэхгүй бүхлээр нь уншаад, хураачхаад юмыг яаж мэдэх вэ, унагахыг байг гэхгүй шүү дээ. Өчигдөр бол бид нарын бодоогүй юм унаж байна лээ. Тэгэхээр тэр эрсдэлээс нь хамгаалаад, хуучин баталсан юмаа ядахдаа үлдэг гэж бодож тэр 43.1 гэсэн юмны 2 хэсэг байгаа шүү дээ. Тэрийг нь нэмье гэсэн санал хураах нь зөв шүү.

**С.Бямбацогт:** За тэгвэл тооцож, шинэ 43.1 дээр тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн дотор томилно гэсэн агуулгаар зарчмын зөрүүтэй саналыг бэлдэж, чуулганы хуралдаанд оруулах нь байна шүү. Ингэж ойлголцлоо шүү. Санал хураачихсан сая. 22.3 дээр 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас түүнчлэн үүгээр саналын томьёолол бэлдэж Чуулганы нэгдсэн хуралдаанд санал хураагдах нь байна. Ингэж ойлголцлоо. Санал хураачихсан.

Одоо Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга ирсэн байна. Ерөнхийлөгчийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Ерөнхийлөгчийн нөгөө бүрэн эрх, Ерөнхийлөгчид тавих шалгууртай холбоотой өөрчлөлтийг бас бид нар яаж байгаа. Төслөөр бол 2025 оны 7 сарын 01-нээс үйлчилнэ гэж байсан. Ажлын хэсэг дээр бол 2021 оноос 7 сарын 01 байвал яасан юм гэж ярьсан. Өөр байдлаар бас томьёолоод, шинэ Үндсэн хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбоотойгоор шинэ Үндсэн хуулийн орчинд бас Ерөнхийлөгчийн сонгууль явах ёстой байх гэдэг саналууд бас яригдсан. Үүнтэй холбоотой Ерөнхийлөгчийн байр суурийг сонсьё гэсэн юм. Энхболд даргын микрофоныг өгье.

**3.Энхболд:** Анх санаачлахдаа 2025 байсныг 2021 болгох гэж байгаа юм байна, тийм ээ? Энэ ингэх нь зүйтэй л дээ. Яагаад гэхээр Үндсэн хууль өөрчлөгдсөн байдаг, дахиад хуучин Үндсэн хуулийн дагуу сонгууль явуулаад байх нь 2021 болгох нь зүйтэй. Гэхдээ техникийн хувьд ийм хүндрэлүүд гарна, энийг ажлын хэсэг, Байнгын хороо, Улсын Их Хурал харгалзаж үзэхгүй бол болохгүй. Тэрийгээ шинэ сонгуулиас хойш мөрдөнө гэхээр тэрний өмнө явах, 2021 оны 5 сард явагдах Ерөнхийлөгчийн сонгууль өөрөө шинэ хуулиар явах ёстой. Тэр шинэ хуулиа гаргахын тулд Ерөнхийлөгч сонгуулийн хуулиа өөрчлөх ёстой. Тэгэхээр тэр өдрөөс эхэлж мөрдөж болохгүй, ядаж жилийн өмнө, хагас жилийн өмнө мөрдөхгүй болохоор Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульдаа 6 жилд 1 удаа гэдгээ хийж чадахгүй, хугацаа өөрчлөгдөхгүй шүү дээ.

Тэгэхээр Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиа батлаад, тэр хууль баталсны дараа оролцох гэж байгаа хүмүүс нь бэлтгэлтэй байхаар бодоод, ядаж хагас жилийн өмнө Улсын Их Хурлын сонгуулийн хуулийг өөрчилдөг шиг процессуудаа явуулаад, гэхдээ тэр хооронд одоогийн ажлаа хийж байгаа

Ерөнхийлөгчийг 2021 онд ажлаа дуусах хүртэл нь ажлаа хийх бололцоог нь хангаж өгөхийн тулд нэг шилжилтийн хууль бичихгүй бол болохгүй байх гэж бодож байгаа. 25-ыг 21 болгохоос гадна тийм практик шаардлага гарах болов уу. Яагаад гэвэл Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулна. Тэрний дагуу хүмүүс өрсөлдөнө. Тэр хүмүүс хэн нэг нь шалгараад Ерөнхийлөгч болсны дараа нь энэ хууль чинь үргэлжилж эхлэх биш, сонгууль явуулахаас өмнө Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийн хугацааг тавихгүй бол болохгүй гэдэг ийм байр суурьтай байна.

**С.Бямбацогт:** Тэгэхээр түрүүн бид нар нэлээн ярилцсан, энэ дээр. Тэгээд яах вэ төслийн 2 дугаар зүйлийг хасах гээд санал хураагдчих юм бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт маань 2020 оны 5 сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болоод явчихна. Түүнтэй холбоотой Ерөнхийлөгчтэй холбоотой заалт хүчин төгөлдөр болоод явчих учраас түүнтэй холбоотой, холбогдох зохицуулалтуудыг холбогдох органик хуулиудад хийж явах бололцоо боломж бүрдээд, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгууль бол шинэ Үндсэн хуулийн эрх зүйн орчинд явах бололцоо, боломж нь бүрдчихнэ гэж үзэж байгаа. Энэ дээр өөр саналтай гишүүд байхгүй биз дээ. Энийг хасах саналаар явчих, болж байгаа юу? Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Яах вэ, 2020 оны 5 дугаар сарын 25-аас хэрэгжинэ гэдэгт нь оруулчхаж байгаа юм байна шүү дээ, хэрэгжих хугацааг нь. Тэгэхдээ нөгөө одоо бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгчийн юугаа тавьж өгөхгүй юм уу? Шинэ сонгууль эхэлснээс энэ заалт хэрэгжиж эхлэн гэдэг нөгөө 6 жилээ. Тэгвэл тэр заалтыг оронд нь тавьж өгөх хэрэг гарах байх л даа. Үгүй, үгүй. Одоогийн бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгчийн байна шүү дээ. Тэгэхээр тэр заалт чинь хэрэгжээд эхэлчхэж байгаа байхгүй юу. Одоо бид нарын 6 жилийн хугацаа гэдэг заалт. 39-ийн хэд билээ дээ. Тэгэхээр тэр заалтын хэрэгжилтийн, зөвхөн тэр заалтынхаа хэрэгжилтийг 2021 сарын 7 сарын 01 гэхгүй юм уу? Тийм 6, хэд гэдэг юм. Тэр нөгөө Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаан дээр чинь юм гаргаж эхлэх юм биш үү? Тэгэхээр бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Ерөнхийлөгчийн хувьд л яриад байна л даа, би.

**С.Бямбацогт:** Лүндээ гишүүн.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр Ерөнхийлөгч, Монгол Улсын Үндсэн хуулийн 30 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025 онд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөнө гээд одоо байж байна. Энийг 2021 он болгоё гэж, тийм үү? Одоо ингээд санал хураагдах нь байна. Ингэсний дараа нөгөө Сонгуулийн хуулийг өөрчлөх барих, ямар асуудлууд гарах бол? Тэгээд энийг дагаж мөрдөнө гэхээр нөгөө Сонгуулийн хуулиа өөрчлөх асуудал чинь, тийм үү? юу болох юм бэ гэдэг асуултыг Энхболд дарга тавиад байна шүү дээ. Энэ нөхцөлд бид байна шүү дээ, ингэж л ойлгосон шүү дээ.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх асуудлыг Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана гээд. Тэгэхээр Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд оруулж байгаа. Ерөнхийлөгчийн хугацаатай холбоотой заалтууд бол Ерөнхийлөгчийн тухай болон Ерөнхийлөгчийн Сонгуулийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ямар ч байсан дор хаяж 2020 ондоо багтаагаад, тийм үү? 6 сарын өмнө ч байдаг юм уу тэрийг хийх нь ээ.

Харин хүчин төгөлдөр болох хугацаагаа би тэгсэн шүү дээ, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2020 оны 5 дугаар сараас эхлээд хүчин төгөлдөр болох юм бол яг хүчин төгөлдөр болох хугацаагаа энэ 2020 оны эхээр хийчих юм бол тэрнээс хойш хүчин төгөлдөр болгохыг нь тавина. 5 сарын 25-аас хойш хийгээд явахад бол проблем үүсэхгүй юм. Энэнтэй холбогдуулаад Ерөнхийлөгчийн холбоотой бас шүүх эрх мэдэлтэй холбоотой заалт байгаа. Энэ бол сая Тогтохсүрэн нарын гишүүдийн гаргасан энүүгээр бол зарчмын зөрүүтэй саналын томъёолол ирсэн байгаа юм.

Төсөлд Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн баталсны үндсэн дээр 2021 сарын 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэдэг зүйлийг нэмье гэж. Тэгэхээр энийг харин наашлуулах уу, тодорхой хугацаа тавих уу гэдэг асуудлаар түрүүн ингээд нээлттэй орхичхоод байгаа. Энэ дээр Энхболд даргын саналыг бас сонсчих нь зүйтэй байх.

**С.Бямбацогт:** Зандан дарга, дараа нь Энхболд дарга.

**Г.Занданшатар:** Түрүүн яг энэ асуудлаар асууж тодруулаад, энэ дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль бол Үндсэн хуулийн нэг адил хүчин төгөлдөр, нэгт. Нэмэлт, өөрчлөлтийн адил нэг адил хүчинтэй, нэгт.

Хоёрт, хамгийн гол заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэл хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуучин хуулиа баримтална. Тэгэхээр тэр шинэ зохицуулалтын хууль батлагдах хүртэл одоогийн Ерөнхийлөгчийн статустай холбоотой асуудал хөндөгдөхгүй, ингээд хэвээрээ байна гэсэн үг л байхгүй юу.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Энэ хуваариа батлахдаа, одоо энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтөө Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг батлагдах хүртэл хүчинтэй байх нь. Тэр нь одоо 12 сарын 31-ний дотроо батлагдах ёстой гэдэг юм уу. 2 сарын 1-нд Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлаж байсан юм байна лээ. Тэр хүртлээ хүчинтэй байх юм уу? Тэгээд тухайн үеийнхээ зохицоод явчих учраас энийгээ, 2 дугаар зүйлээ хасаад явчихъя гэсэн түрүүний Товуусүрэн гуайн тодруулга бол үндсэндээ зарчмын хувьд ингээд зохицуулагдаад явчихаж байна. 25, 21 гэдгийг чинь хасаад санал хураачихаар 2020 оны 5 сарын 25-наасаа энэ адил, нэг адил хүчин төгөлдөр үйлчлээд явчихна гэсэн үг.

**С.Бямбацогт:** Энхболд дарга 2 дугаар микрофон.

**3.Энхболд:** Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн сахилгын хороо хоёр дэмжигдээд, зөвшилцлийн ажлын хэсгээр явж байгаа гэж би ойлгож байгаа зөв үү, тиймээ. Тэгэхээр тэр хоёрыг заавал 2020 оны 5 сарын 20 гэх хэрэггүй л дээ. Маргаашнаас хэрэгжүүлээд явахгүй бол энэ авлига авдаг шүүхийнхээ системтэй дахиад жил явна гэж байж болохгүй шүү дээ. Тэр хоёр байгууллага бол нэн даруй Үндсэн хууль батлагдлаа, шууд хэрэгжүүлээд явлаа, шинээр байгууллаа.

Тэгээд энэ шүүхийнхээ системийг цэгцэлж эхлэх хэрэгтэй. Тэрийг бол хойш нь тавих хэрэггүй.

Ерөнхийлөгч Ардчилсан намын Үндсэн хуулийн өөрчлөлтийг ард түмнээрээ хэлэлцүүлэх санал асуулгыг дэмжээд, тэр санал асуулга явуулахыг дэмжсэн Ардын намын бүлгийн шийдвэрт бас талархаж байгаа. Тэгэхдээ энэ ард түмнээсээ асуудаг дээр зөвхөн Үндсэн хуулийн энэ одоогийн өөрчлөлтөө асуух бол учир дутагдалтай байна. Яагаад гэхээр Ерөнхий сайд нь кабинетаа, гишүүдээ мэддэггүй, мэддэг байх санал унасан. Давхар дээлтэй, давхар дээлгүй байх санал унасан. Сонгуулийн системийн сайн муу талын аль аль нь агуулдаг, сайн муу талыг саармагжуулж болох холимог систем унасан. 5 жил унасан, 108 унасан. Тэр энэ нь одоогийн өөрчлөлтийг реформын шинжтэй болсон гэж үзэхгүй байгаа.

Тийм учраас Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасны дагуу засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байдаг энэ бол тунхаг биш гэж үзэж байгаа юм бол засаглалынхаа хэлбэрийг ард түмнээсээ одоогийн ээлжит болон ээлжит бус сонгуулийнхаа үеэр явах саналын хуудсан дээр заавал бишээ. Монголын ард түмэн Ерөнхийлөгчийн засаглалтай байх юм уу, парламентын засаглалтай байх юм уу. Энэ зааврыг авсан шинээр байгуулагдах Улсын Их Хурал шинэ Үндсэн хуулиа энэ зааврын дагуу хийгээд тарнаа. Шилжилтийн Их Хурал. Тэгээд энэний дараагийн дараагийн сонгуулиар гарах Их Хурал ард түмэн Ерөнхийлөгчийн засаглалыг сонговол Ерөнхийлөгч ард түмнээсээ сонгогдоно. Ард түмэн парламентын сонгуулийг сонгогдвол Ерөнхийлөгч Парламентаасаа сонгогдоно, Герман маягийн.

Ерөнхийлөгчийн сонгууль дээр кнопоо дарах юм бол Америк маягийн Үндсэн хуультай. Хоорондоо эрх мэдлийн тэнцвэржсэн зохицуулалттай. Энэ хоёр замын аль нэгээр явахыгаа ард түмнээсээ заавал асуу гэдэг саналыг Улсын Их Хуралд санал асуулгынхаа текстийг удахгүй ирүүлнэ. Ингэхгүй бол одоогийн Үндсэн хуулиа сайжруулаад явна гэж бодсон чинь ямар нэгэн одоо бодитой өөрчлөлт олдсонгүй. Төрийн өмчийг нийтийн өмч гэснээс өөрөөр одоо гялтайх юм алгаа гэж дүгнэж байгаа шүү.

Тэгэхээр энэ өөрчлөлтийг Улсын Их Хурал яаж ч батлаад гаргасан Ерөнхийлөгчийн байр суурь бол Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1-ийгээ хэрэгжүүлэх зорилгоор нэгэнт санал асуулга явахаар шийдсэн бол тэрэн дээр Ерөнхийлөгч асуулт нэмж өгнөө. Тэрийг батлах, батлахгүй нь бол Улсын Их Хурлын ажил болоод үлдэнэ. Ер нь бол өөрчлөлтөө хийгээд, ажилладаг Үндсэн хуультай болоод, улс орныхоо хөгжлийг шинэ шатанд гаргая, энэн шиг одоо хуучин 76 тойргоо санагалзаад тэрнээсээ салж чаддаггүй, хуучин гишүүн нь сайд байдаг, тэр нэг боломжоо хаахыг хүсэхгүй ингээд явах юм бол энэ чинь реформ биш байна л гэж байгаа юм. Тэгэхээр одоо энэ өнөөдрийн хэлэлцүүлэг, дараагийн 7 хоногийн хэлэлцүүлгээс ямаршуу байдалтай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гарах вэ тэрнээс хамаараад Ерөнхийлөгч ард нийтийн санал асуулгад явуулах саналынхаа томъёоллыг бэлдэж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Саяны санал дээр та тэгээд хасаад явчихад ойлгомжтой болох юм байна, тийм үү? 2 дугаар зүйлийг хасах гэсэн санал хураалтыг явуулахад сая бол гишүүд ярилцаад ерөнхийдөө бол тийм харшлах зүйл байхгүй юм байна, 1 дүгээр зүйл дээрээ бол одоогийн хууль хүчин төгөлдөр

болтол Үндсэн хуулийн нэмэлт шинэ хууль батлагдтал одоогийн хууль хүчин төгөлдөр байна. Үүнтэй холбогдуулж хууль батлах ажил хийнээ гэгчихсэн болохоор. Санал хураалт явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. Хасахыг дэмжье.

Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 13 гишүүн буюу 92.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ингээд өөр зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Сая тэр шүүхтэй холбоотой асуудал ярина гэсэн үү, ярихгүй гэсэн үү? Санал гаргах хүн байхгүй юу тиймээ? За санал гаргах хүн байхгүй бол тэгээд.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Санал, дүгнэлтийг Бямбацогт уншина.

За Оюун-Эрдэнэ гишүүн. Түр байж байгаарай. Байнгын хорооны хурал хаагдаагүй байгаа шүү. Түр нээчихээрэй.

**Л.Оюун-Эрдэнэ:** Ажлын хэсгийн гишүүд, Байнгын хорооны гишүүддээ хандаж би бас хоёр дахь удаагаа нэг зүйлийг хэлэх гээд байгаа юм л даа. Ялангуяа Лүндээжанцан дарга, ажлын хэсгийнхэнд.

Одоо өмнөх бидний одоогийн барьж байгаа Үндсэн хууль бол үнэхээр яруу тод монгол хэлээр бичсэн, утга, уянгын хувьд хоёр салаа утгатай нэг ч өгүүлбэр байхгүй ийм Үндсэн хууль аа. Одоо бидний нэмэлт, өөрчлөлтүүд яах уу утга агуулгын хувьд дэвшилттэй зүйлүүд олон байгаа ч, яг ингээд уншихаар одоо үнэхээр яг монгол хэлний ялангуяа тэр зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр эд нар бол холбоос туйлын учир дутагдалтай байна. Одоо үндэсний баялгийн санд төвлөрүүлнэ гэгчихэж байгаа. Энийг болохоор зарчимд суурилна гэх юм уу? тэгээд уул гишүүн энэ тэр гээд орж байгаа юм. Уул гишүүн байх юм уу, уг гишүүн байх юм уу?

22.3 бол одоо маш урт өгүүлбэр. Энэ дотроо одоо бүр нөгөө нэг Ерөнхий сайдыг огцруулснаас түүнчлэн гээд ингээд юу тавьчихсан ийм асуудлууд гарч ирээд байдаг. Хяналт гээд хаалтан дотор аудитыг энэ тэр гээд олон л ийм асуудлууд байна л даа. Тэгэхээр энэ нэг ингээд нэг сайн бодохгүй бол ингээд нэг албаар ингээд хийчихсэн юм шиг хожмын нэг өдөр энэ чинь нөгөө нэг эрхэм дээд Үндсэн хууль гээд айл бүхний хойморт заларна. 10 жилийн сургуулийн хүүхдүүд болон оюутнууд үзнэ. Тэгэхээр энийгээ их сайн бодохгүй бол болохгүй шүү, Лүндээ даргаа. Тэгээд бид нарын хувьд одоо ингээд яах вэ батлаад батлаад явчихдаг. Үг, үсгийн алдаатай, утгын агуулга алдаатай, дараа нь олон янзаар тайлбарлагдаад Цэц дээр очих ийм асуудал үүсэх вий. Энийг одоо яг хэн хариуцаж байгаа юм бэ.

Би уул нь дээр ажлын хэсэгт энэ монгол хэл бичгийн хүн хэн байнаа, дэд ажлын хэсэг байгуулж өгөөч ээ гээд уул нь хүсэлт тавьсан. За гэж Төрийн байгуулалтын байнгын хороон дээр тухайн үед алх цохиж байсан шүү дээ. Тэгээд энэ маань одоо яг хэзээ хийгдэх вэ. Энийг нэг тодруулаад асуучихмаар байх юм. Санаа зовж байна яг үнэндээ.



**С.Бямбацогт:** Хэлний зөвлөл бас ажиллаж байгаа. Монгол хэлний зөвлөл. Тэгээд энэ дээр одоо манай Тамгын газар еше илүү бас хариуцлагатай нэмж бас ажиллая. Нарангэрэл, Базаррагчаа гэсэн монгол хэлний зөвлөл бас улсын тийм хэлний зөвлөл байдаг юм байна лээ. Тэднийх ажиллаж байгаа. Энэ дээр бид бас анхаарах ёстой. Лүндээ гишүүн бас нэмээд тийм.

**Д.Лүндээжанцан:** Тэгэхээр ийм байгаа шүү. Ингэж байгаа. 5 хэсэг дээр найруулгын санал орно гэж байгаа юм. 5 газар байгаа юм. Тэр нөгөө нэг шаваас болчихсон шүү дээ, сүүлдээ. Тэрийг ч оруулна, энийг ч оруулна гэсээр байгаад шаваас болчихсон. Тэр болгоныг янзална. Уул гишүүн гээд уул гэдэг үг бол одоогийн Үндсэн хуульд уул гээд явчихсан байна. Мөнхүү шалтгаанаар гэдэг үг хоёр газар билүү одоогийн Үндсэн хуульд байна. Тэгэхээр бид одоогийн Үндсэн хуульд одоо нөгөө шинэ хэлний юугаар бас зарим өөрчлөлтүүд орчихсон учраас одоогийнхоороо явахгүй Үндсэн хуулийнхаа хэлээр явахгүй бол тийм үү үг, нэр томъёонуудыг зарим нь одоо гараг гэхэд “а”-гаар бичдэг болчихсон, тэрийг бид хуучнаар нь явахаас өөр арга байхгүй байгаа.

Тэгээд бид хэлнийхэнтэйгээ ярина. Эх баригчийн туслах ажлын хэсэг гэж байгаа. Арга зүйн туслалцаа үзүүлэх. Энэ дээр бас хуульчид суугаад тэгэхдээ бид байна шүү дээ ба, бэ-гүй өөрчлөх эрхгүй байгаа юм бас. Ерөнхий бас нөгөө хуулиар хорьчихсон юмнууд байна. Гэхдээ байна шүү дээ яг ингээд нөгөө нэг өгүүлбэрийн байршил, хавсарсан нийлмэл өгүүлбэрүүдийг багасгах, тэгээд одоо төлөөний үг буюу одоо тэрийг аль болохоор бага оруулах гэх мэтчилэнгээр хууль тогтоомжийн техниктэй холбоотой, хууль зүйн техниктэй холбоотой юмнуудаар үг, үсгийг нь хянан засвар хийнэ. Тэрийгээ ард нийтийн санал асуулгад оруулах нэг, хоёрдугаар хэлэлцүүлгийн явцад нэг бүрчлэн тайлбарлаж оруулахгүй бол бидний энэ үг ингэж алга болсон гэх гээд байдаг байхгүй юу. Шийдэгдсэн асуудал. Тэрийг нь болохоор бол одоо бас нэг бүрчлэн тайлбар хийж авч үзэхээс өөр арга алгаа.

Ийм учраас манай Тамгын газар, ажлын хэсэг, дээр нь дэд ажлын хэсэг байгаа юм. Яг энийг хариуцсан дэд ажлын хэсэг. Энэнтэйгээ бид нар хамт хуралдаж суугаад ингээд 25 дугаар зүйлд орсон өөрчлөлтүүд байгаа шүү дээ тиймээ. Төсөв, төлөвлөгөө, байгалийн баялагтай холбоотой 6 дугаар зүйлийг. Ерөнхий сайдыг огцруулахтай холбоотой асуудлаар. Одоо тэгэхдээ бол тэрийг өөрчлөх гэхээр бас болж өгөхгүй. Яг хуучин хуулийнхаа заалттай очиж хашигдаад байгаа юм.

Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хороо хоёртой холбоотой заалтыг бол хамаагүй гар хүрч болохгүй болчихоод байна. Энэ мэтчилэнгээр бол бид бүхэн найруулга хийгээд явах нь зүйтэй гэсэн Их Хурлын даргаас өгөөд гишүүд дунд нь санал гаргаад ингэсэн 5 асуудал байна. Тэгээд энэ бол яг бүхэл бүтэн Үндсэн хууль биш учраас нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бол цөмөөрөө уншаад сайн анхаарчих боломж бол бидэнд байна лээ.

Сая, өчигдөр орой, өнөө өглөө бид нар уншаад нэг бүрчилж уншиж байна. Тэгээд одоо гурав, дөрөв дэх уншилтын үед бол ингээд янзлагдаад гарчихна. Хамаагүй гар хүргэж болохгүй байна. Одоогийн яг Үндсэн хуулийнхаа нэр томъёо, үг хэллэгээр нь явах асуудал бас тулчихаад хоёр өөрөөр томъёологдож болохгүй байгаа юмаа гэдгийг хэлье. Анхаарал, энд их ач холбогдол өгч анхаарал тавьсанд бас баярлалаа. Оюун-Эрдэнэ гишүүн ээ, баярлалаа гэдгээ бас хэлье.

**С.Бямбацогт:** За тэгээд 1992 оны шинэ Үндсэн хуулийн эх баригч, одоо бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг барьж байгаа Лүндээжанцан гишүүн бас их анхаарч ажиллах байх аа, эх барьж байгаа хүн бас. Парламентад тасралтгүй сонгогдсон ганц гишүүн маань одоо их анхаараарай. Тамгын газар бас туслаарай, хэлний зөвлөлийнхөн бас анхаарч байгаа байх аа гэж бодож байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

Д.ЦЭНДСҮРЭН

П.ОЮУНГЭРЭЛ

Б.БААСАНЖАВ /Гэрээт/

Б.УРАНЧИМЭГ /Гэрээт/

Д.ЭНЭБИШ /Гэрээт/